



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/75/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: [tsaranchimeg@audit.gov.mn](mailto:tsaranchimeg@audit.gov.mn)

<b>Товчилсон үгийн жагсаалт</b> .....	3
<b>2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл</b> .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
<b>3. Аудитын тайлан</b> .....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
<b>4. Аудитын илрүүлэлт</b> .....	17
4.1 Залруулсан алдаа .....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.4 Зөвлөмж.....	19
<b>5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл</b> .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС      Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС      Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/150  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН ӨНДӨРШИРЭЭТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Г.ЦЭЦЭГМАА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 БААЦБАН ВИСНГ 19020477

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>102,377,918.34</b>	<b>98,563,408.34</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	9,000,000.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	9,000,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	9,000,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	93,377,918.34	98,563,408.34
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	00.00	2,784,500.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	2,784,500.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	9,592,000.00	9,891,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	43,325,918.34	47,297,408.34
35410	Бичиг хэргийн материал	1,441,740.00	1,390,300.00
35420	Аж ахуйн материал	30,720,093.90	22,571,423.90
35430	Сэлбэг хэрэгсэл	1,000,000.00	11,470,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	56,600.00
35450	Барилгын засварын материал	00.00	1,645,000.00
35470	Бусад хангамжийн материал	10,164,084.44	10,164,084.44
35500	Биологийн хөрөнгө	7,720,000.00	7,720,000.00
35600	Мал амьтад	32,740,000.00	30,870,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>940,663,167.15</b>	<b>936,680,538.54</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	940,663,167.15	936,680,538.54
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	923,186,117.15	919,496,498.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	744,924,987.00	756,672,696.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-123,121,289.17	-152,946,952.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	174,742,519.00	174,742,519.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-73,340,617.26	-102,775,152.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	68,429,853.00	73,712,353.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,636,345.94	-27,668,309.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,687,342.30	18,687,342.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,204,317.44	-7,186,251.57
39209	Зам, гүүрийн байгууламж	96,956,054.00	98,756,054.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-14,290,864.84	-16,406,799.16
39214	Бусад үндсэн хөрөнгө	145,532,785.00	217,243,192.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-99,493,988.50	-113,334,191.87
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	17,477,050.00	17,184,040.00
39301	Програм хангамж	2,135,100.00	2,135,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-670,050.00	-963,060.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,012,000.00	16,012,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,043,041,085.49</b>	<b>1,035,243,946.88</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,043,041,085.49</b>	<b>1,035,243,946.88</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,043,041,085.49	1,035,243,946.88
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	425,137,525.38	425,137,525.38
51101	Өмч: - төрийн	425,137,525.38	425,137,525.38
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	420,391,902.98	412,594,764.37
51210	Өмнөх үеийн үр дүн	420,391,902.98	420,391,902.98
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-7,797,138.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	197,511,657.13	197,511,657.13
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,043,041,085.49</b>	<b>1,035,243,946.88</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>647,626,679.99</b>	<b>507,425,818.19</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>220,304,201.14</b>	<b>140,519,744.19</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	219,734,201.14	138,881,994.19
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	219,734,201.14	138,881,994.19
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,456,057.34	36,811,098.19
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	17,725,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	197,278,143.80	84,345,596.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	570,000.00	1,637,750.00
122001	Хандив тусламж /дотоод/	570,000.00	1,637,750.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>427,322,478.85</b>	<b>366,906,074.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	69,149,478.85	16,307,674.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	69,149,478.85	16,307,674.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	358,173,000.00	350,598,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	358,173,000.00	350,598,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>490,828,679.15</b>	<b>515,222,946.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>485,838,679.15</b>	<b>506,222,946.80</b>
<b>210</b>	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	464,134,523.67	469,768,204.92
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	227,538,036.00	227,535,165.37
210101	Үндсэн цалин	227,421,473.00	227,535,165.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,921,247.71	29,031,301.91
210201	Тэтгэврийн даатгал	19,330,226.71	20,466,046.30
210202	Тэтгэмжийн даатгал	2,274,220.00	2,275,370.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,819,376.00	1,820,296.71
210204	Ажилгүйдлийн даатгал	408,856.00	406,323.85
210205	Эрүүл мэндийн даатгал	4,088,569.00	4,063,264.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,043,730.00	23,887,534.00
210301	Гэрэл, цахилгаан	2,629,730.00	3,840,034.00
210302	Түлш, халаалт	21,384,000.00	20,047,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	39,833,516.41	63,930,407.40
210401	Бичиг хэрэг	4,122,540.00	2,292,140.00
210402	Тээвэр, шатахуун	13,816,503.81	19,336,167.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,198,000.00	4,235,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	1,080,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,696,472.60	36,987,100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	799,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	799,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35,000,000.00	318,000.00
210604	Урсгал засвар	35,000,000.00	318,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,083,000.00	2,398,000.00
210702	Дотоод албан томилолт	4,083,000.00	2,398,000.00

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	19,880,592.00	2,401,452.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	19,063,092.00	1,765,902.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	236,500.00	216,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	128,000.00	99,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	85,834,401.55	119,466,944.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,116,395.00	24,813,729.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	130,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	67,718,006.55	94,523,214.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	21,704,155.48	36,454,741.88
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	998,000.00	11,253,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	11,253,200.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,</b>	20,706,155.48	25,201,541.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,706,155.48	25,201,541.88
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	4,990,000.00	9,000,000.00
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	4,990,000.00	9,000,000.00
221001	Их засвар	00.00	9,000,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>156,798,000.84</b>	<b>-7,797,128.61</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	142,879.73	10.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	142,879.73	10.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-142,879.73	-10.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>156,655,121.11</b>	<b>-7,797,138.61</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	425,137,525.38	197,511,657.13	426,255,088.21	00.00	1,048,904,270.72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>425,137,525.38</b>	<b>197,511,657.13</b>	<b>426,255,088.21</b>	<b>00.00</b>	1,048,904,270.72
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-5,863,185.23	00.00	-5,863,185.23
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>425,137,525.38</b>	<b>197,511,657.13</b>	<b>420,391,902.98</b>	<b>00.00</b>	1,043,041,085.49
D01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>425,137,525.38</b>	<b>197,511,657.13</b>	<b>420,391,902.98</b>	<b>00.00</b>	1,043,041,085.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>425,137,525.38</b>	<b>197,511,657.13</b>	<b>420,391,902.98</b>	<b>00.00</b>	1,043,041,085.49
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,797,138.61	00.00	-7,797,138.61
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>425,137,525.38</b>	<b>197,511,657.13</b>	<b>412,594,764.37</b>	<b>00.00</b>	<b>1,035,243,946.88</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>449,778,536.19</b>	<b>423,080,222.19</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>22,456,057.34</b>	<b>56,174,148.19</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	22,456,057.34	54,536,398.19
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,456,057.34	54,536,398.19
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,456,057.34	36,811,098.19
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	17,725,300.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	00.00	1,637,750.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	1,637,750.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>427,322,478.85</b>	<b>366,906,074.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	69,149,478.85	16,307,674.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	69,149,478.85	16,307,674.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	358,173,000.00	350,598,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	358,173,000.00	350,598,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>423,938,256.19</b>	<b>423,080,222.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>423,938,256.19</b>	<b>423,080,222.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>402,234,100.71</b>	<b>386,625,480.31</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	227,538,036.00	227,535,165.37
210101	Үндсэн цалин	156,920,174.00	145,008,333.21
210102	Нэмэгдэл	38,113,262.00	49,964,047.35
210105	Гэрээт ажлын хөлс	32,504,600.00	32,562,784.81
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,921,247.71	29,031,301.91
210201	Тэтгэврийн даатгал	25,691,714.44	20,466,045.98
210202	Тэтгэмжийн даатгал	592,835.33	2,294,644.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	474,267.48	1,820,296.68
210204	Ажилгүйдлийн даатгал	105,734.58	404,574.03
210205	Эрүүл мэндийн даатгал	1,056,695.88	4,045,741.05
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,043,730.00	23,887,534.00
210301	Гэрэл, цахилгаан	2,629,730.00	3,840,034.00
210302	Түлш, халаалт	21,384,000.00	20,047,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,013,100.00	22,652,576.40
210401	Бичиг хэрэг	3,999,900.00	2,384,700.00
210402	Тээвэр, шатахуун	13,815,200.00	14,952,876.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,198,000.00	4,235,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	1,080,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	799,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	799,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	36,000,000.00	838,000.00
210604	Урсгал засвар	36,000,000.00	838,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,083,000.00	2,398,000.00
210702	Дотоод албан томилолт	4,083,000.00	2,398,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	36,753,592.00	23,225,383.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	35,936,092.00	22,589,833.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	236,500.00	216,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	128,000.00	99,000.00

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,881,395.00</b>	<b>56,258,119.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,881,395.00	56,128,119.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	130,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21,704,155.48</b>	<b>36,454,741.88</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>998,000.00</b>	<b>11,253,200.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	11,253,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	998,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох</b>	<b>20,706,155.48</b>	<b>25,201,541.88</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,706,155.48	25,201,541.88
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>25,840,280.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>25,840,280.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>25,840,280.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>25,840,280.00</b>	<b>00.00</b>
222001	Тоног төхөөрөмж	18,100,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	7,740,280.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР</b>	<b>-25,840,280.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	368,579,300.00	368,323,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,579,300.00	368,323,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,326,100.00	343,925,920.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,660,900.00	227,535,165.37
210101	Үндсэн цалин	157,056,300.00	145,008,333.21
210102	Нэмэгдэл	38,097,000.00	49,964,047.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,734,200.00	29,031,301.91
210201	Тэтгэврийн даатгал	21,627,800.00	20,466,045.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,276,600.00	2,294,644.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,821,300.00	1,820,296.68
210204	Ажилгүйдлийн даатгал	455,300.00	404,574.03
210205	Эрүүл мэндийн даатгал	4,553,200.00	4,045,741.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,546,300.00	22,766,247.00
210301	Гэрэл, цахилгаан	3,161,400.00	2,718,747.00
210302	Түлш, халаалт	21,384,900.00	20,047,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,625,700.00	21,514,826.40
210401	Бичиг хэрэг	3,052,500.00	2,384,700.00
210402	Тээвэр, шатахуун	13,815,200.00	13,815,126.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,258,000.00	4,235,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариут	1,500,000.00	1,080,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	850,000.00	838,000.00
210604	Урсгал засвар	850,000.00	838,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	817,500.00	635,550.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	236,500.00	216,550.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	128,000.00	99,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,480,900.00	39,206,829.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,480,900.00	39,206,829.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,253,200.00	11,253,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,253,200.00	11,253,200.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	367,941,800.00	355,179,120.31
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,605,536.19	54,756,522.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,605,536.19	54,756,522.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75,873,592.00	42,699,560.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,000,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	59,046,592.00	16,672,231.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59,046,592.00	16,672,231.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,046,592.00	16,672,231.00
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
0	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын бүрдүүлэлт болох е баримт, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн № 03/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь сумын эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого зохицуулалтаар хангах, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад чиглэсэн оновчтой бодлого зохицуулалтаар хангах, захиргааны удирдлага, иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, байгууллагын хүний нөөцийг сайжруулах, хувь хүний чадавх, харилцаа хандлагыг өөрчлөхөд анхаарч, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд дэмжлэгийг үзүүлэх чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллага юм.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/01 тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын багийг, дотоод хяналт зохион байгуулах журмын хамтаар баталсан байна. Тайлант онд 10 ажил төлөвлөж хэрэгжилтийн талаарх тайлан бичиж үр дүнг санхүүгийн албаны даргад танилцуулж ажилласан байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас өвсний тооцоог шалгасан байна. 12 дугаар сард Аймгийн Засаг даргын үзлэг хяналт шалгалт хийсэн байна.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 699,226.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 10,488.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 7,866.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 7,611.3 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 2,877.1 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 5,708.5 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Аймгийн ТЕЗ-ийн байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

#### **Орлого:**

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 350,598.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 16,307.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 84,345.6 мянган төгрөг, өмнөх оны шилжих үлдэгдлээс 17,725.3 мянган төгрөг, бусад орлого 36,811.1 мянган төгрөг, хандив тусламжийн орлого 1,637.8 мянган төгрөг нийт 507,425.8 мянган төгрөг өмнөх оноос 140,200.9 мянган төгрөгөөр буюу 21,6 хувиар буурсан байна.

#### **Зардал:**

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 515,223.0 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 423,080.2 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 368,323.7 мянган төгрөг зарцуулсан байна.

#### **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100141655001 тоот дансанд 2021 онд 423,080.2 мянган төгрөгийн орлого, 423,080.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100141655401 тоот дансанд 54,756.5 мянган төгрөгийн орлого төвлөрч, 54,756.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	9,000.00	-	9,000.00
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	93,377.92	98,563.41	(5,185.49)
Үндсэн хөрөнгө	940,663.17	936,680.54	3,982.63
Нийт хөрөнгө	1,043,041.09	1,035,243.95	7,797.14
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	1,043,041.09	1,035,243.95	7,797.14
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,043,041.09	1,035,243.95	7,797.14

Авлагын дансны үлдэгдэл 0 төгрөг болж 9,000.0 мянган төгрөгөөр буурсан нь Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газрын архивын байр зассан ажлыг хүлээн авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 98,563.4 мянган төгрөг болж 5,185.5 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 2,784.5 мянган төгрөгөөр, сэлбэг хэрэгсэл 10,470.0 мянган төгрөг, барилгын засварын материал 1,645.0 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 936,680.5 мянган төгрөг болж 3,982.6 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,043,041.1 мянган төгрөг болж 7,797.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 416,397.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 416,397.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 47,818.2 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 368,579.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь цалин, шимтгэл 52,658.2 мянган төгрөгөөр зардлыг бууруулсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 368,579.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 368,579.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 368,579.3 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 355,179.1 мянган төгрөгийг зарцуулж, 13,144.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 355,179.1 мянган төгрөг буюу 96,36 хувь зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь нийт 54,756.5 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлсэн байна. Үүнд: өмнөх оны үлдэгдэл 15,731.9 мянган төгрөг, Ковид 19 цар тахлын үед хандиваар 1,637.8 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын захирамжаар 11,500.0 мянган төгрөгийн санхүүжилт, Засгийн газраас үзүүлсэн хөнгөлөлтөөр усны төлбөрт 2,522.2 мянган төгрөг, улсын мал тооллогын санхүүжилт 827.4 мянган төгрөг, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 1,181.3 мянган төгрөг, Зуунмод сумын ЗДТГ-аас 236.8 мянган төгрөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 300.0 мянган төгрөг, өвс, тэжээлийн үнэ иргэдээс 16,642.8 мянган төгрөг, хонь, ямааны үнэ 2,719.0 мянган төгрөг, А дансны архивын лавлагааны хураамж 518.0 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 140.0 мянган төгрөг, оношлуур, тестийн үнэ 799.0 мянган төгрөгийн тус тус орлого орсон байна.

Үүнээс гэрэл цахилгааны зардалд 1,121.3 мянган төгрөг, түлш шатахуун 1,137.8 мянган төгрөг, эм бэлдмэлийн зардалд 799.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 22,589.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 16,921.3 мянган төгрөг, бусад зардал 130.0 мянган төгрөг нийт 42,699.2 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 12,057.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант оны батлагдсан зардлаас Ковид-19-ын цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 3,750.0 мянган төгрөг, цэрэг татлагад зориулж халдвар хамгааллын хэрэгсэлд 216.0 мянган төгрөг, мөн шүлхий өвчнөөс урьдчилан

сэргийлэх ариутгалын бодис 346.5 мянган төгрөг, нийт 4,312.5 мянган төгрөгийг төсвөөс зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн аймгийн Засаг даргын А/72, А/128, А/518 дугаар захирамжуудаар ирсэн 11,500.0 мянган төгрөгийг тусгаарлах байрны зардалд 2,532.0 мянган төгрөг, Ковид 19 цар тахлын үед бэлтгэл бэлэн байдлын зардалд 6,270.0 мянган төгрөг, оношлуурт 799.4 мянган төгрөг, шатахууны зардалд 2,137.8 мянган төгрөг, бусад зардалд 3,040.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 8,726.0 мянган төгрөгийн, аймгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 81,814.6 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаа хоцроосон 2, хугацаандаа байршуулсан 147 мэдээлэл байна. Шилэн дансны цахим хуудсанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болон орлогын дүнг мэдээлэх мэдээллээс 6 үнийн дүнгээр 407,821.0 мянган төгрөгийн мэдээллийг буруу мэдээлснийг аудитын явцад залруулсан.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 54,756.5 мянган төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулан тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны

тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 15-ний өдрийн №03/48 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Хэрэгжилтийг 100.0% биелүүлсэн гэж дүгнэлээ.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар шатахууны тооцоог шалгах

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 102,544.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 71,638.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 29,483.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,422.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

### **4.1 Залруулсан алдаа**

Барилга байгууламжийн дансанд 11,747.7 мянган төгрөгийн худаг /Баянтуул Цахирын өндөр толгой/, бусад үндсэн хөрөнгийн дансанд 59,891.2 мянган төгрөгийн спорт чийрэгжүүлэлт сүүдрэвч, хүүхдийн тоглоом, хашаа зэрэг хөрөнгийн орлогыг бүртгэлгүй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### **4.2 Төлбөрийн акт**

Төв аймаг 2020 оны үйл ажиллагаагаар "Шилдэг аймаг"-аар, тус сум нь аймгийн хэмжээнд 5 дугаар байранд шалгарсан үндэслэлээр 4 ажилтанд 0.5 сарын цалингаар шагнаж, 422.6 мянган төгрөгийн шагналыг цалингийн зардлаас гаргаж төсвийг зориулалт бус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 тоот тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын 1-д 2101 цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 210104 “Урамшуулал гэдэгт ... нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшууллын

зардал хамаарахгүй” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

#### **4.3 Албан шаардлага**

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг харилцагч байгууллагын НӨАТ-ийн цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 25,557.3 мянган төгрөгийн гүйлгээ тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын НХМаягт 5 “Төлбөрийн баримт нь ... Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах ...” гэж заасныг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

Тайлант онд эд хогшил, тоног төхөөрөмж авах зардал батлагдаагүй байхад 12 дугаар сард 3,926.0 мянган төгрөгийн нөөтбүүк, принтер, татварын пос машин авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 тоот тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож,

давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал үүссэн бол” албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв

#### 4.4 Зөвлөмж

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Өндөрширээт сумын Засаг даргын Тамгын газар	4	102,544.8	1	71,638.9	1	1,422.6	2	29,483.3	0	0